

(Fe,Mn)WO<sub>4</sub>-ийн БҮТЦИЙН БОЛОН  
СОРОНЗОН ШИНЖ ЧАНАРЫН  
СУДАЛГАА

H. Ehrenberg<sup>1</sup>, M. Wiesmann<sup>1</sup>, I. Svoboda<sup>1</sup>, H. Weitzel<sup>1</sup>,  
H. Fuess<sup>1</sup>, Д. Сангаа<sup>2</sup>

<sup>1</sup> Fachbereich Materialwissenschaft, Technische Hochschule  
Darmstadt, Petersenstr. 23, D-64287, German

<sup>2</sup> Монгол Улсын Их Сургууль, Физикийн Факультет

Товч дүгнэлт:

Байгалийн нунтаг дээж FeWO<sub>4</sub> ба MnWO<sub>4</sub> дээр рентген цацрагийн дифракц ба соронзон мэдрэх чадвар ( $\chi$ )-ийн температурын хамаарлыг судалжээ.

Рентген дифракцийн хэмжилтээс кристалл торын тогтмолуудыг Ритвельдийн аргаар нарийвчлан тооцоолжээ. Соронзон мэдрэх чадварын температурын хамаарлаас урьд ажиглагдаагүй нэгэн шилжилт буйг ажигласан байна.

### 1. Оршил

FeWO<sub>4</sub> ба MnWO<sub>4</sub> нэгдлүүд нь бага катионтой металл вольфрамын хоёр валентын шилжилттэй бүлгийн изоморф гишүүдийн нэг юм. AWO<sub>4</sub> бүлгийн нэгдлүүдийг (A=Mg, Mn, Fe, Co, Ni, Zn, Cd, Cu) хүчилтөрөгчийн ионоор няйт дүүргэгдсэн хувирсан гексагонал тор байж болох вольфрамийн бүтцээр төлөөлдөг. A<sup>2+</sup>, W<sup>6+</sup> - катионууд O, A, O, W... гэсэн дараалсан үеүүдийн хоорондох октоэдрийн 1/4 зайд байрладаг.

Иймээс бүтэц нь өөртөө z-тэнхлэгт параллель шилжилттэй октоэдр AO<sub>6</sub> буюу WO<sub>6</sub>-ийн отплогдсон завсарын зиг-заг хэлхээг агуулсан байдаг[1-2].

FeWO<sub>4</sub> ба MnWO<sub>4</sub>-ийн бүтцийг моноклиник сингони, огторгуйн групп нь P2/c гэж тодорхойлсон байна[3-4].

Торын параметрууд нь:

FeWO<sub>4</sub>  
a=4.73 Å,  $\alpha=90^\circ$   
b=5.70 Å,  $\beta=89^\circ 55'$

MnWO<sub>4</sub>  
a=4.82 Å,  $\alpha=90^\circ$   
b=5.76 Å,  $\beta=89^\circ 07'$

$c=4.95 \text{ \AA}$ ,  $\gamma=90^\circ$

$c=4.97 \text{ \AA}$ ,  $\gamma=90^\circ$

$(\text{Mn},\text{Fe})\text{WO}_4$  -ийн соронзон мэдрэх чадварыг  $(\text{Mn},\text{Fe})$ -ийн харьцаанаас хамааруулан судалсан байна[4].

$\text{MnWO}_4$  -хувьд Нээлийн цэг ба соронзон момент нь:  $T_N = 14.4^\circ\text{K}$ ,  $\mu = 5.83 \mu_\text{B}$

$\text{FeWO}_4$  -хувьд харгалзах параметр нь  $T_N = 75.9^\circ\text{K}$ ,  $\mu = 5.41 \mu_\text{B}$ . Дээрх Нээлийн температурууд ба соронzon моментууд нь  $\text{FeWO}_4$  -ээс  $\text{MnWO}_4$  хүртэл хоёр фазын концентрациас ойролцоогоор шугаман хамаарлтай өөрчлөгдөх болоод энэ нь тухайн дээж  $(\text{Fe}_x\text{Mn}_{1-x})\text{WO}_4$  -д Mn ба Fe-ийн процентыг тодорхойлох арга болгон хэрэглэх боломжийг олгож байна [4].

## 2. Туршилтын хэсэг.


### 1. Рентген дифрактометрийн хэмжилт.

$(\text{Fe},\text{Mn})\text{WO}_4$ -ийн нунтаг дээжийг тасалгааны температурт Со К- $\alpha$  цацраг ашиглан рентген дифрактометр STOE дээр хэмжилтийг явууллаа. Хэмжилтийн үр дүng боловсруулахын өмнө стандарт "Powder Diffraction Program Library" программ ашиглан дээжийн нэгэн терлийн фазтай болохыг тодруулсан юм. Уг дээжийн кристалл торын параметрууд болон Fe, W, O атомуудын байршил, температурын параметрыг тодорхойлохын тулд Ритвельдийн анализыг FULLPROF программын[6] тусламжтай гүйцэтгэлээ. Торын параметрын анхны утуууд, атомуудын координат, температурын факторыг [7]-оос авлаа.

Зураг.1-д  $(\text{Mn},\text{Fe})\text{WO}_4$ -ийн дифрактограммын боловсруулалтын үр дүng харуулав.


### 2. Соронзон мэдрэх чадварыг хэмжилт.

Материалын соронзон чанар гадны соронзон орноос яаж хамаарч байна вэ гэдгийг соронзон мэдрэх чадвар  $\chi=M/H$  харуулдаг. Хэмжилтийг LakeShore фирмийн соронзон мэдрэх багаж (Susceptometer) дээр явууллаа



Зураг.1.  $(\text{Fe}_x\text{Mn}_{1-x})\text{WO}_4$ -ийн Ритвельд анализ хийсэн рентгенидифрактограмм.

Дээжийн соронзон шинж чанарыг соронзон орны хүч Н-ийн тусламжтай соронзжилт М-ийг өөрчлөх замаар тодорхойллоо.. Нунтаг дээж  $(\text{Fe}_x\text{Mn}_{1-x})\text{WO}_4$ -ийн нэвтрүүлэлт  $\chi$ -г 20-200 К температурийн мужид хэмжсэн юм. Энэ хэмжилтийн ур дунг зураг.2-д узуулэв. 75K ба 143K температурийн уед хоёр максимум ажиглагдсны эхнийх нь вольфрамитийн антиферромагнетик фазад харгалзана. Хоердугаар максимум нь 2-р соронzon фазийн нолоо юм. Гэсэн ч дээжийн рентген цацрагийн дифракцаар нэмэлт пикууд ажиглагдсан. Эдгээр фазийг оорчлох боломжгүй юм. Зураг.2-д  $(\text{Fe}_x\text{Mn}_{1-x})\text{WO}_4$ -ийн соронзон мэдрэх чадвар ба температурын хамаарлыг харуулав.



Зураг.2.  $(\text{Fe}_x\text{Mn}_{1-x})\text{WO}_4$ -ийн соронзон мэдрэх чадварын температурын хамаарал

Үр дун

а) Рентген дифракцийн хэмжилтээс гарах дүгнэлт.

Рентген цацрагийн дифрактограммыг боловсруулах Ритвельд анализын FULLPROF программыг ашиглан торын параметрууд болон атомуудын байшил, дулааны хэлбэлзлэлийн коеффициентийг нарийвчлан тодорхойлсон юм.

Тодорхойлсон торын параметруудыг  $\text{\AA}$  ба енцгийг градусаар илэрхийлбэл:

$a=4.7342(8)$ ;  $b=5.7086$ ,  $c=4.9632(13)$ ;  $\alpha=90.0$ ;  $\beta=89.9703(8)$ ;  
 $\gamma=90.0$

Атомуудийн байршил ба температурын факторийг Хүснэгт.1-д харуулав.

### Хүснэгт.1

Атом	x	y	z	B	эзлэх хувь
Mn/Fe	0.50000	0.67188 (3)	0.25000	1.12	0.5
W	0.00000	0.18199 (4)	0.25000	1.34	0.5
O1	0.07427 (5)	0.01572 (6)	0.76039 (5)	1.45	1.0
O2	0.09019 (7)	0.35837 (6)	0.27524 (5)	1.43	1.0

b) Соронзон чанарын хэмжилтээс хийх дүгнэлт.

Хольцолсон дээж дахь  $\text{FeWO}_4$ -ийн процентыг дараахь томьеогоор [4] соронзон хэмжилтийн үр дунг ашиглаж Нээлийн температурын утгаас тодорхойлсон юм.

$$x = (T_{N_{(Mn)}} - T_{N_{(Mn)}}) / (T_{N_{(Fe)}} - T_{N_{(Mn)}}) = 0.99$$

Энд:  $T_N$ -Нээлийн температур

$T_{N_{(Mn)}}$  - Нээлийн температур ( $\text{MnWO}_4$ )  
 $T_{N_{(Fe)}}$  - Нээлийн температур ( $\text{FeWO}_4$ )

Соронzon хэмжилтийн энэ арга нь дурын хольцын концентрацитай геологийн дээжуудийн хувьд харгалзах фазуудын орцын хэмжээг тодорхойлох арга болж байгаа нь ихээхэн практик ач холбогдолтой юм.

#### Дүгнэлт

Уг нунтаг дээжийн кристалл торын Fe / Mn атомууд ямар харьцаатай харилцан солилцон суурьших нь торын параметрын утга болон атом хоорондын зайн хэмжээнд хэрхэн нөлөөлдгүйг рентген туяаны дифракцийн хэмжилтийн үр дунгээс тодорхойлж болдгийг харууллаа. Соронзон хэмжилтээр ажиглагдсан нэмэлт шилжилтийн хувьд Fe / Mn өөр

харьцаа бүхий дээж дээр уг хэмжилтийг дахин хийх шаардлагатайг харуулав.

### Талархал

Хэмжилтийн үр дүнг боловсруулахад болон дээж бэлдэхэд гүн туслалцаа үзүүлсэн д-р Г.Миехе, проф. Ж. Лхамсүрэн нарт талархлаа илэрхийлье.

### Ашигласан ном зохиол

1. Weitzel, H.  
Kristallstrukturverfeinerung von Wolframiten und Columbiten.  
*Z.Kristallogr.*, 144 (1966), 238-258.
2. Ulku, D.  
Untersuchungen zur Kristallstruktur und magnetischen Structur des Ferberits FeWO<sub>4</sub>.  
*Z.Kristallogr.*, 124 (1967), 192-219.
3. Dachs H.; Weitzel, H. & Stoll, E.  
Magnetic Structure of Manganesetungstate MnWO<sub>4</sub> at 4,2 K.  
*Solid State Commun.* 4 (1966), 473-74.
4. Weitzel, H.  
Suszeptibilitäten von Mischkristallen (Mn,Fe)WO<sub>4</sub> Wolframit.  
*N. Jb. Miner. Abn.*, 113 (1970), 13-28.
5. Rietveld, H.M.  
A profile refinement method for nuclear and magnetic stuctures.  
*J.App.Crystallogr.* 2, (1969), 65-71.
6. Rodriguez-Carvajal J.  
Abstracts of Satellite Meeting of the XY Congress of the Int. Union of Crystallography, Toulouse (1990) p.127.
7. Weitzel, H.  
Neutronenbeugeng an Mischkristallen (Mn,Fe)WO<sub>4</sub> Wolframit.  
*Z.Kristallogr.*, 131 (1970), 289-313.